

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	20
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МАЛ ЭМНЭЛГИЙН ЭМИЙН СОРИЛТ,
БАТАЛГААЖУУЛАЛТЫН УЛСЫН
ЛАБОРАТОРИ УТУГ-ЫН
ЗАХИРАЛ А.ОРГИЛ ТАНАА

2021.02.25 № 07/506
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТУГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТУГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 98.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>243 124 928,89</u>	<u>288 191 824,40</u>
33	АВЛАГА	96 689 470,26	48 342 691,97
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	102 740,19
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	12 688 702,00	44 133 552,00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	84 000 768,26	-
335	Бусад авлага	-	4 106 399,78
3351	Байгууллагаас авах авлага	-	4 106 399,78
34	УРЬДЧИЛГАА	66 854,39	-
34600	Урьдчилж гарсан зардал	66 854,39	-
35	БАРАА МАТЕРИАЛ	146 368 604,24	239 849 132,43
351	Түүхий эд материал	12 057 250,08	102 098 505,49
35110	Тусгай зориулалттай материал	9 345 860,08	100 147 335,49
35130	Эм боох материал	2 711 390,00	1 951 170,00
354	Хангамжийн материал	111 900 454,16	109 166 051,94
35410	Бичиг хэргийн материал	4 783 613,00	4 140 386,00
35420	Аж ахуйн материал	73 578 216,93	80 489 804,83
35430	Сэлбэг хэрэгсэл	-	184 600,00
35440	Түлш, шатах тослох материал	753 000,00	3 539 000,00
35470	Бусад хангамжийн материал	32 785 624,23	20 812 261,11
35600	Мал амьтад	22 410 900,00	28 584 575,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>934 842 618,90</u>	<u>926 374 950,04</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	934 842 618,90	926 374 950,04
392	Биет хөрөнгө	877 632 800,93	897 157 327,78
39201	Барилга, байгууламж, орон сууц	575 351 872,00	560 261 802,00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(38 060 324,18)	(67 219 189,83)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40 038 000,00	132 838 000,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(35 371 333,49)	(44 961 333,53)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1 037 119 159,05	1 065 639 313,01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(708 908 441,70)	(760 458 347,61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47 486 732,40	49 560 742,40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(40 142 863,15)	(38 623 658,66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	120 000,00	120 000,00
393	Биет бус хөрөнгө	57 209 817,97	29 217 622,26
39301	Програм хангамж	7 010 000,00	7 010 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1 484 444,46)	(3 472 777,74)
39303	Бусад биет бус хөрөнгө	52 697 400,00	25 680 400,00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1 013 137,57)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1 177 967 547,79</u>	<u>1 214 566 774,43</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>199 716,00</u>	<u>824 231,00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	199 716,00	824 231,00

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын
2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

413	Өглөг	199 716,00	824 231,00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	199 716,00	218 631,00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	326 000,00
4136	Бусад өглөг	-	279 600,00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	279 600,00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1 177 767 831,79</u>	<u>1 213 742 543,43</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1 177 767 831,79	1 213 742 543,43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1 233 840 996,88	1 233 840 996,88
51101	Өмч: - төрийн	1 233 840 996,88	1 233 840 996,88
512	Хуримтлагдсан үр дүн	(507 214 981,15)	(441 378 910,75)
51210	Өмнөх үеийн үр дүн	(663 908 166,84)	(477 353 622,39)
51220	Тайлант үеийн үр дүн	156 693 185,69	35 974 711,65
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	451 141 816,06	421 280 457,30
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1 177 967 547,79</u>	<u>1 214 566 774,43</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1 125 132 053,99	1 026 449 253,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	123 616 323,99	252 778 733,00
120	Нийтлэг татварын бус орлого	123 616 323,99	252 778 733,00
120002	Хүүгийн орлого	192 509,99	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	123 423 814,00	252 778 733,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	123 423 814,00	227 539 519,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	25 239 214,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 001 515 730,00	773 670 520,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	714 962 050,00	752 846 300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	714 962 050,00	752 846 300,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	286 553 680,00	20 824 220,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189 823 680,00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	96 730 000,00	20 824 220,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	968 438 868,30	938 493 576,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	968 438 868,30	938 493 576,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	882 807 908,20	832 157 255,35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125 237 573,13	418 107 094,00
210101	Үндсэн цалин	125 237 573,13	235 199 389,00
210102	Нэмэгдэл	-	147 135 705,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	35 772 000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18 220 975,67	57 935 727,82
210201	Тэтгэврийн даатгал	10 585 406,09	40 362 141,83
210202	Тэтгэмжийн даатгал	1 245 341,00	4 230 917,83
210203	ҮОМШӨ-ний даатгал	2 218 576,00	4 147 232,12
210204	Ажилгүйдлийн даатгал	242 233,00	835 621,44
210205	Эрүүл мэндийн даатгал	3 929 419,58	8 359 814,60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19 246 000,00	26 811 100,00
210301	Гэрэл, цахилгаан	7 646 400,00	15 423 929,80
210302	Түлш, халаалт	9 943 900,00	11 387 170,20
210303	Цэвэр, бохир ус	1 655 700,00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	16 226 764,57	55 633 425,50
210401	Бичиг хэрэг	4 428 309,00	10 168 439,26
210402	Тээвэр, шатахуун	8 132 850,00	9 650 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 152 900,01	993 594,54

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын
2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210404	Ном, хэвлэл	27 000,00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5 000,00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2 480 705,56	33 389 974,70
210408	Бараа материал акталсны зардал	-	1 431 417,00
2105	Нормативт зардал	179 806 579,80	1 197 769,26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	179 806 579,80	1 197 769,26
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	221 000,00	24 741 555,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	68 000,00	7 212 400,00
210604	Урсгал засвар	153 000,00	17 529 155,00
2107	Томилолт, зочны зардал	11 919 448,00	3 793 066,00
210701	Гадаад албан томилолт	9 559 248,00	-
210702	Дотоод албан томилолт	1 931 600,00	3 793 066,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	428 600,00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	340 015 137,16	41 974 847,01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	337 375 747,16	32 961 315,01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2 046 310,00	6 445 500,00
210803	Даатгалын үйлчилгээ	71 280,00	136 620,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	130 532,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	487 500,00	2 047 800,00
210807	Газрын төлбөр	-	231 080,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	34 300,00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	171 914 429,87	201 962 670,77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68 616 127,24	85 349 853,26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3 710 000,00	4 848 000,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	99 588 302,63	111 764 817,51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85 630 960,10	106 336 320,65
2132	Бусад урсгал шилжүүлэг	8 519 000,00	36 771 761,01
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5 793 000,00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	25 652 776,01
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2 726 000,00	11 118 985,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	77 111 960,10	69 564 559,64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	77 111 960,10	69 564 559,64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	156 693 185,69	87 955 677,00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	51 980 965,35
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	51 980 965,35
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(51 980 965,35)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	156 693 185,69	35 974 711,65

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1 111 124 751,99</u>	<u>1 049 744 757,26</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	109 609 021,99	192 073 469,00
120	Нийтлэг татварын бус орлого	109 609 021,99	192 073 469,00
120002	Хүүгийн орлого	192 509,99	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	109 416 512,00	192 073 469,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	109 416 512,00	192 073 469,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1 001 515 730,00	857 671 288,26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	714 962 050,00	752 846 300,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	714 962 050,00	752 846 300,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	286 553 680,00	104 824 988,26
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	189 823 680,00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	96 730 000,00	104 824 988,26
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1 112 249 999,38</u>	<u>957 485 457,26</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 112 249 999,38	957 485 457,26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	944 699 271,02	849 573 221,61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	125 237 573,13	418 217 586,34
210101	Үндсэн цалин	125 237 573,13	235 309 881,34
210102	Нэмэгдэл	-	147 135 705,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	35 772 000,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18 220 975,67	57 935 727,82
210201	Тэтгэврийн даатгал	16 713 874,33	40 362 141,83
210202	Тэтгэмжийн даатгал	-	4 230 917,83
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	4 147 232,12
210204	Ажилгүйдлийн даатгал	-	835 621,44
210205	Эрүүл мэндийн даатгал	1 507 101,34	8 359 814,60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19 246 197,47	23 657 600,00
210301	Гэрэл, цахилгаан	8 750 100,00	9 147 200,00
210302	Түлш, халаалт	9 944 097,47	12 530 400,00
210303	Цэвэр, бохир ус	552 000,00	1 980 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	17 528 700,01	18 974 924,54
210401	Бичиг хэрэг	6 061 850,00	5 810 300,00
210402	Тээвэр, шатахуун	8 870 850,00	12 171 030,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 301 400,01	993 594,54
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5 000,00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700 000,00	-

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын
2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	589 600,00	-
2105	Нормативт зардал	44 469 850,00	6 141 200,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44 469 850,00	6 141 200,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14 041 380,00	42 782 391,50
210601	Багаж, техник, хэрэгсэл	8 881 600,00	7 300 000,00
210602	Тавилга	4 184 000,00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	14 894 750,00
210604	Урсгал засвар	975 780,00	20 587 641,50
2107	Томилолт, зочны зардал	11 619 448,00	3 802 036,00
210701	Гадаад албан томилолт	9 559 248,00	-
210702	Дотоод албан томилолт	1 931 600,00	3 802 036,00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	128 600,00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	625 710 589,66	106 659 817,01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	620 938 479,66	95 455 285,01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2 046 310,00	8 636 500,00
210803	Даатгалын үйлчилгээ	-	136 620,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	130 532,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2 691 500,00	2 047 800,00
210807	Газрын төлбөр	-	231 080,00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	34 300,00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68 624 557,08	171 401 938,40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64 214 557,08	166 223 938,40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4 410 000,00	5 178 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	167 550 728,36	107 912 235,65
2132	Бусад урсгал шилжүүлэг	6 438 000,00	38 347 676,01
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	6 093 000,00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	25 652 776,01
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	345 000,00	12 694 900,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	161 112 728,36	69 564 559,64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	161 112 728,36	69 564 559,64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(1 125 247,39)</u>	<u>92 259 300,00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	92 259 300,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	92 259 300,00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	92 259 300,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	92 259 300,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-</u>	<u>(92 259 300,00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(1 125 247,39)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1 125 247,39	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 233 840 996,88	451 141 816,06	-663 908 166,84	1 021 074 646,10
Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	156 693 185,69	156 693 185,69
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 233 840 996,88	451 141 816,06	-507 214 981,15	1 177 767 831,79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0,00	0,00	29 861 358,76	29 861 358,76
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1 233 840 996,88	451 141 816,06	-477 353 622,39	1 207 629 190,55
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0,00	-29 861 358,76	0,00	-29 861 358,76
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0,00	0,00	0,00	0,00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0,00	0,00	0,00	0,00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0,00	0,00	0,00	0,00
Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	35 974 711,65	35 974 711,65
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1 233 840 996,88	421 280 457,30	-441 378 910,74	1 213 742 543,44

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	892 846 400,00	876 633 797,62	16 212 602,38	98,2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	892 846 400,00	876 633 797,62	16 212 602,38	98,2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	861 117 400,00	844 905 121,61	16 212 278,39	98,1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418 439 500,00	418 217 586,34	221 913,66	99,9
210101	Үндсэн цалин	240 751 100,00	235 309 881,34	5 441 218,66	97,7
210102	Нэмэгдэл	141 542 400,00	147 135 705,00	(5 593 305,00)	104,0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36 146 000,00	35 772 000,00	374 000,00	99,0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58 349 400,00	57 935 727,82	413 672,18	99,3
210201	Тэтгэврийн даатгал	40 171 700,00	40 362 141,83	(190 441,83)	100,5
210202	Тэтгэмжийн даатгал	4 544 500,00	4 230 917,83	313 582,17	93,1
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 635 500,00	4 147 232,12	(511 732,12)	114,1
210204	Ажилгүйдлийн даатгал	908 900,00	835 621,44	73 278,56	91,9
210205	Эрүүл мэндийн даатгал	9 088 800,00	8 359 814,60	728 985,40	92,0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23 657 600,00	23 657 600,00	-	100,0
210301	Гэрэл, цахилгаан	9 147 200,00	9 147 200,00	-	100,0
210302	Түлш, халаалт	12 530 400,00	12 530 400,00	-	100,0
210303	Цэвэр, бохир ус	1 980 000,00	1 980 000,00	-	100,0
2104	Хангамж, бараа материалын зардал	18 975 700,00	18 974 924,54	775,46	100,0
210401	Бичиг хэрэг	5 810 300,00	5 810 300,00	-	100,0
210402	Тээвэр, шатахуун	12 171 800,00	12 171 030,00	770,00	100,0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	993 600,00	993 594,54	5,46	100,0
2105	Нормативт зардал	6 141 200,00	6 141 200,00	-	100,0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6 141 200,00	6 141 200,00	-	100,0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58 805 000,00	44 941 691,50	13 863 308,50	76,4
210601	Багаж, техник, хэрэгсэл	19 875 000,00	9 459 300,00	10 415 700,00	47,6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14 930 000,00	14 894 750,00	35 250,00	99,8
210604	Урсгал засвар	24 000 000,00	20 587 641,50	3 412 358,50	85,8

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын
2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	3 802 100,00	3 802 036,00	64,00	100,0
210702	Дотоод албан томилолт	3 802 100,00	3 802 036,00	64,00	100,0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104 397 600,00	103 660 417,01	737 182,99	99,3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	92 555 200,00	92 455 885,01	99 314,99	99,9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8 637 500,00	8 636 500,00	1 000,00	100,0
210803	Даатгалын үйлчилгээ	555 000,00	136 620,00	418 380,00	24,6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	139 000,00	130 532,00	8 468,00	93,9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	173 100,00	22 000,00	151 100,00	12,7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2 047 800,00	2 047 800,00	-	100,0
210807	Газрын төлбөр	290 000,00	231 080,00	58 920,00	79,7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	168 549 300,00	167 573 938,40	975 361,60	99,4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	167 196 600,00	166 223 938,40	972 661,60	99,4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1 352 700,00	1 350 000,00	2 700,00	99,8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31 729 000,00	31 728 676,01	323,99	100,0
2132	Бусад урсгал шилжүүлэг	31 729 000,00	31 728 676,01	323,99	100,0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25 652 800,00	25 652 776,01	23,99	100,0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6 076 200,00	6 075 900,00	300,00	100,0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	892 846 300,00	876 633 797,62	16 212 502,38	98,2
1320	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	752 846 300,00	684 560 328,62	68 285 971,38	90,9
122005	Улсын төсвөөс	752 846 300,00	684 560 328,62	68 285 971,38	90,9
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	140 000 000,00	192 073 469,00	-52 073 469,00	137.2
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140 000 000,00	192 073 469,00	-52 073 469,00	137.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32	32		
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	23	23		
620003	Үйлчлэх ажилтан	8	8		

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)		104 824 988,26
21	УРСГАЛ ЗАРДАЛ		22 024 988,26
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		14 127 400,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		7 300 000,00
210601	Багаж, техник, хэрэгсэл		7 300 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2 999 400,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2 999 400,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		3 828 000,00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		3 828 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		7 897 588,26
2132	Бусад урсгал шилжүүлэг		6 619 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6 619 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		1 278 588,26
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		1 278 588,26
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		82 800 000,00
222	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ		82 800 000,00
222001	Тоног төхөөрөмж		82 800 000,00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)		104 824 988,26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		104 824 988,26
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		104 824 988,26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		104 824 988,26
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын захирал А.Оргил танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төсвийг зохистой удирдах, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Пийк ОМ Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 17 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ нь үндсэн зорилгоо “Монгол Улсын нутаг дэвсгэрт мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал сүргийг эрүүлжүүлэх, нийтийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, малын эм, био бэлдмэлийн чанарын сорилт, баталгаажуулалтыг үндэсний болон олон улсын фармакопейн шаардлагад нийцүүлж чанартай, баталгаатай эм, био бэлдмэлийг хэрэглэгчдэд нийлүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэн ажиллах” гэж тодорхойлсон байна.

2020 онд зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдуулан үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- “Монгол Улсын 2020 оны төсвийн тухай” хуулийн XV.1.14 дугаарт батлагдсан төсвийн дагуу “Амь сорил, био аюулгүйн лабораторийн барилга”, “Конторын барилга” барих;
- “Дэлхийн банк”-ны санхүүжилтээр хэрэгжих төслийн хүрээнд төлөвлөгөө, төсөл, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх;
- Орон нутгаас сахуу, шөвөг яр өвчний өсгөвөр гарган авах;
- Мал эмнэлгийн зориулалтаар шинээр зохион бүтээсэн, үйлдвэрлэсэн, импортолсон малын эм, био бэлдмэл, эмийн түүхий эдэд сорилт, туршилт, шинжилгээ хийх, чанарыг баталгаажуулах;
- Монгол Улсын MNS ISO/IEC 17025:2018, MNS ISO/IEC 17065:2013 стандартуудын хүрээнд сорилт, баталгаажуулалтын итгэмжлэлийн хугацааг сунгуулах;

- Мал эмнэлгийг чанарын баталгаатай, эм био бэлдмэлээр хангах, төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс эм, био бэлдмэлийг тохирлын үнэлгээнд хамруулан тохирлын гэрчилгээ олгох;
- Малын эрүүл мэндийн нэгдсэн цахим систем үүсгэхтэй холбоотойгоор “Мал, амьтны эм, вакцины үйлдвэрлэл, мониторингийн мэдээллийн систем”-г бий болгоход мэдээллийг бэлтгэх, нэвтрүүлэх, сорилтын дүн, баталгаажуулалтын дүгнэлт гаргах үйл ажиллагааг цахим системд шилжүүлэх;
- Лабораторийн багаж тоног төхөөрөмж, компьютер, техник, хэрэгслийг шинэчлэх;
- Лабораторийн шинжилгээнд ашиглаж буй, эм урвалж, стандарт бодисыг шаардлага хэрэгцээгээр бүрэн хангах;
- Эмч мэргэжилтнүүд, албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, гадаад дотоодын сургалт, семинар, төсөл, хөтөлбөрүүдэд хамруулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хөдөө аж ахуйн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 502,776.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 5,027.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг хагас жилийн үзүүлэлт тул гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагатай гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 909,474.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,904.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 36,599.2 мянган төгрөгөөр буюу 3,1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	96,689.5	48,342.7	(48,346.8)
Урьдчилгаа	66.8		(66.8)
Бараа материал	146,368.6	239,849.1	93,480.5
Үндсэн хөрөнгө	934,842.6	926,375.0	(8,467.6)
Нийт хөрөнгө	1,177,967.5	1,214,566.8	36,599.3
Өр төлбөр	199.7	824.2	624.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,177,767.8	1,213,742.6	35,974.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,177,967.5	1,214,566.8	36,599.3

Авлага дансны эхний үлдэгдэл 96,689.5 мянган төгрөг нь 84,000.7 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлага, 12,688.7 мянган төгрөгийн дансны авлагаас бүрдэж байсан ба татаас санхүүжилтийн авлага барагдаж дансны авлага 48,342.7 мянган төгрөг болж 35,674.0 мянган төгрөгөөр өссөн нь малын гоц халдварт өвчний эм, био бэлдмэлийн шинжилгээ нэмэгдсэнээс 2020 онд үндсэн үйл ажиллагааны орлого өссөн, гоц халдварт өвчин цар тахалын дэгдэлт их гарсантай холбоотой байгууллагын шинжилгээний хуваарьт өөрчлөлт орж шинжилгээний хариу хойшилж гарч байгаагаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 239,849.1 мянган төгрөг болж 93,480.5 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын онцлог шинж чанартай холбоотой туршилтын мал амьтан, эм, урвалж, оношлуур, омогийн нээлттэй, харьцуулалтын аргын тендер зарлаж онцгой шалгуур хангасан бараа бүтээгдэхүүнийг худалдан авалт хийсэн ба тухайн бараа бүтээгдэхүүнийг шууд зардлын дансанд бүртгээгүй, тухайн авсан лабораторийн эрхлэгч тус бүрт дотоод хөдөлгөөнөөр шилжүүлж бүртгэсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 926,374.9 мянган төгрөг болж 8,467.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдэл хорогдлын зардал болон 51,981.0 мянган төгрөгийн дансны үнэтэй хөрөнгүүдийг холбогдох тушаал шийдвэрийн дагуу акталж данснаас хассанаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 130,538.3 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 14,739.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө нь 29,217.6 мянган төгрөг болж 27,992.2 мянган төгрөгөөр буурсан нь 26,003.9 мянган төгрөгийн дансны үнэтэй туршилтын байр, лабораторийн конторын барилгын зургуудыг биет хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн болон тайлант хугацааны хорогдуулгын зардлаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 824.2 мянган төгрөг болж 624.5 мянган төгрөгөөр өссөн нь төрийн сангийн гүйлгээ хаагдахаас өмнө зарим төлбөрөө шилжүүлж амжилгүй мөнгөө татуулснаас шалтгаалжээ.

Бусад 279.6 мянган төгрөгийн өр нь шинжилгээний төлбөрийг олон удаагийн давтамжтайгаар төлдөг харилцагч илүү шилжүүлснээс шалтгаалан үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,213,742.5 мянган төгрөг болж 35,974.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны санхүүгийн үр дүнгээс шалтгаалжээ. Энэ нь хуримтлагдсан алдагдлыг бууруулж улмаар засгийн газрын хувь оролцоог нэмэгдүүлсэн байна.

Мал эмнэлгийн эмийн сорил, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 98,682.8 мянган төгрөгөөр буюу 8.8 хувиар буурсан байна. Үйл ажиллагааны орлого буурсан гол шалтгаан нь өмнөх онд дээд шатны байгууллагаас 189,823.6 мянган төгрөг буюу 16,8 хувийн санхүүжилтийг бүрдүүлж ажиллаж байсан бол 2020 онд өөрийн үйл ажиллагааны орлогоор 140,000.0 мянган төгрөг, улсын төсвөөс 813,573.9 мянган төгрөг нийт 953,573.9 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж ажиллахаас 2020 оны улсын төсвийн тодотголоор Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардлаас 60,727.6 мянган төгрөгийн санхүүжилтийг бууруулсан зэргээс шалтгаалан үйл ажиллагааны санхүүжилтийн нийт орлогод нөлөө үзүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь өмнөх оноос 104,115.7 мянган төгрөг буюу 84.4 хувиар өссөн байна. Үүний гол шалтгаан нь өмнөх онд давсан орлого 96,730.0 мянган төгрөг байсан бол 2020 онд давсан орлого 20,824.2 мянган төгрөг буюу 75.9 хувиар буурсан, өмнөх онд өөрийн орлого бүрдүүлж байгаагүй бол 2020 онд 140,000.0 сая төгрөгийг бүрдүүлж ажиллахаар төлөвлөсөн нь давсан орлогыг бууруулсан байна.

Нийт зардал өмнөх оноос 29,945.3 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Мал эмнэлгийн эмийн сорил, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ нь 2020 онд улсын төсвөөс 813,573.9 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 1,632,000.0 мянган төгрөгийн хөрөнгийн санхүүжилт авах, өөрийн үйл ажиллагааны орлогоор 140,000.0 мянган төгрөг, нийт 2,585,573.9 мянган төгрөгийн бүрдүүлж зарцуулах төсвийн төсөл бэлтгэж төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

2020 онд 1,632,000.0 мянган төгрөгийн барилгын санхүүжилт нь ХХААХҮЯ-ны багцад хуваарилагдаж, тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны санхүүжилтэд 813,573.9 мянган төгрөгөөр батлагдсан байна. Үүнээс 2020 оны улсын төсвийн тодотголоор Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардлаас 60,727.6 мянган төгрөгийн санхүүжилтийг бууруулж 752,846.3 мянган төгрөгөөр дахин баталсан байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 892,846.3 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 752,846.3 мянган төгрөг, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоор 140,000.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 752,846.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 212,897.6 мянга, нийт 965,743.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж,

урсгал үйл ажиллагаанд 892,846.4 мянган төгрөгийг зарцуулж давсан орлогоос 20,824.2 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилт рүү олгож, улсын төсөвт 52,073.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 876,633.8 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардлаас 972.7 мянга, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас 1,150.8 мянга, цалин хөдөлмөрийн хөлсний зардлаас 221.9 мянга, шатахуун, эд хогшил, урсгал засварын зардлаас 463.3 мянга, нийт 2,812.6 мянган төгрөг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд давсан орлогоос 20,824.2 мянга, татаас санхүүжилтийн авлагын 84,000.7 мянган төгрөгийг Сангийн яамнаас авч нийт 104,825.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж байгууллагын хэрэгцээнд шаардлагатай 82,800.0 мянган төгрөгийн авто машин худалдан авч, 20,746.4 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 1,278.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 116 мэдээллийг хугацаанд нь, 31 мэдээллийг хугацаа хоцроож Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 291.9 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 33.3 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 8,765.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,888.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,473.1 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 5,404.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Хэвлэгчтэй таблетийн элэгдлийн зардлыг 312.6 мянган төгрөгөөр илүү байгуулсныг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.
2. Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулахаар 1,575.9 мянган төгрөгийг үйлдвэрчний эвлэлийн дансанд шилжүүлсэн ба цар тахлаас хамаарч үйлчилгээ аваагүй боловч тайлант хугацааны зардалд хүлээн зөвшөөрч, авлага үүсгээгүй байсныг залруулга хийлгэсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 1,473.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,473.1 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тус байгууллагын захирлын 2020.03.16-ны А/36 дугаартай тушаалын дагуу 2020.03.19-ний өдөр шилжүүлсэн дотоодын албан томилолтын 408.8 мянган төгрөгийн зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж тус тус заасантай нийцэхгүй, Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллаж, алдаа зөрчлийг арилгаж, цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлээ.

2. Шилэн дансны цахим системд мэдээллээ хугацаанд нь байршуулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй, тайлант хугацааны 31 мэдээллийг хугацаа хоцроон оруулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай нийцэхгүй, Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг арилгаж, Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь ил тод, бүрэн оруулж байх албан шаардлага хүргүүлээ.

3. Тус байгууллагын захирлын 2020.09.21-ний өдрийн А/106 дугаартай “Ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлж, мөнгөн урамшуулал олгох тухай” тушаалаар, холбогдох эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр захирал Ц.Гантөмөр өөртөө 398.3 мянган төгрөгийн урамшуулал олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж тус тус заасантай нийцэхгүй, Үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, алдаа зөрчлийг арилгаж, цаашид холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлээ.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 5,404.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц бусад асуудал гараагүй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус байгууллагын захирлын 2020.05.08-ны өдрийн А/62 дугаартай “Хүүхдийн бэлэг олгох тухай” тушаалын дагуу Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас Дотоодын цэргийн 05 дугаар ангийн алба хаагчдын хүүхдүүдэд 200.0 мянган төгрөгийн бэлэг өгсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2-д "Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үрэгдэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төсвийн тухай хуулийн 6.4.1, 6.4.2 дох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 1,688.1 мянган төгрөгийн авлага /Стандарт хэмжил зүйн болон төлбөртэй үйлчилгээний авлага ороогүй/ болон 824.2 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.2. Эрсдэл: Төсвийн тухай хууль зөрчигдөх, төсвийг зүй зохистой зарцуулаагүй байх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4.8 дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3. Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд 2,691.8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн

нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

3.2. Эрсдэл:

Төсвийн тухай хууль зөрчигдөх, найдваргүй авлага үүсэх,

3.3. Өгсөн зөвлөмж:

Авлага, өр төлбөрийг тооцоо нийлж, актаар баталгаажуулж байх, Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллах;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.19	Аудитын нэр: Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/11/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус байгууллагын захирлын 2020.05.08-ны А/62 дугаартай Хүүхдийн бэлэг олгох тухай тушаалын дагуу Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас Дотоодын цэргийн 05 дугаар ангийн алба хаагчдын хүүхдүүдэд 200,000 бэлэг өгсөн байна.	200.0	Зөвлөмж хүргүүлэх	Захирал, нягтлан бодогч	А.Оргил, Д.Байгалмаа
2	Тайлант хугацаанд 1,688.1 мянган төгрөгийн авлага /төлбөртэй үйлчилгээний авлага ороогүй/ болон 824,2 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.	2,512.3	Зөвлөмж хүргүүлэх	Захирал, нягтлан бодогч	А.Оргил, Д.Байгалмаа
3	Тайлант онд 2,691.8 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	2,691.8	Зөвлөмж хүргүүлэх	Захирал, нягтлан бодогч	А.Оргил, Д.Байгалмаа
4	Тус байгууллагын захирлын 2020.03.16-ны А/36 дугаар тушаалын дагуу олгосон дотоодын албан томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	408.8	Албан шаардлага хүргүүлэх	Захирал, нягтлан бодогч	А.Оргил, Д.Байгалмаа
5	Шилэн дансны цахим системд мэдээллээ хугацаанд нь байршуулах зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлээгүй, тайлант хугацааны 31 мэдээллийг хугацаа хоцроон оруулсан байна.		Албан шаардлага хүргүүлэх	Захирал, нягтлан бодогч	А.Оргил, Д.Байгалмаа
6	Тус байгууллагын захирлын 2020.09.21-ний өдрийн А/106 дугаартай "Ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлж, мөнгөн урамшуулал олгох тухай" тушаалаар, холбогдох эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр Захирал Ц.Гантөмөр өөртөө 398.3 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон байна.	398.3	Албан шаардлага хүргүүлэх	Захирал, нягтлан бодогч	А.Оргил, Д.Байгалмаа
ДҮН		6,211.3			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 45/АД160063
САН-2021/11/СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 149 мэдээлэл байршуулахаас 31 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь ил тод, бүрэн оруулж биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын захирал А.Оргил, ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭРДЭНЭЗУЛ
А.МӨНХЦЭЦЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 46/АД160063

Улаанбаатар хот

СДТ-2021/11/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын захиралд холбогдох дээд албан тушаалтны шийдвэргүйгээр 398.3 мянган төгрөгийн урамшуулалт цалин олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Албан тушаалтан өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, мөн эдгээрт бэлтгэхэд өөрийн албан тушаалын байдлаа ашиглан аливаа хэлбэрээр хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно” гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, алдаа зөрчлийг арилгаж биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын захирал А.Оргил, ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭРДЭНЭЗУЛ
А.МӨНХЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 47/А0160063

Улаанбаатар хот

СМГ-2021/11/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хийгдсэн 408.8 мянган төгрөгийн худалдан авалт анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдлийг ханга ажиллаж, алдаа зөрчлийг арилгаж биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори УТҮГ-ын захирал А.Оргил, ерөнхий нягтлан бодогч Д.Байгалмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЗУЛ

ПИЙК ОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

А.МӨНХЦЭЦЭГ

ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing conclusions.